



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

2023.03.15 № 07/515
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 255 дугаар тогтоолоор байгууллагын дүрмийг шинэчлэн баталж, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газар 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр бүртгэсэн байна.

Тайлант онд 90830 м.кв талбайтай 5 нэгж талбай дахь газрын эрхийг 2,941.8 сая төгрөгөөр үнэлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А-1/2654 дугаар албан тоотын дагуу биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 635 дугаар тушаалаар Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 2022 оны нийт орлогыг 6,120.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,986.6 сая төгрөгөөр, 119.9 сая төгрөгийн ашигтай байхаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,191.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 6,808.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,138.5 сая төгрөгийн зардал гарган, 540.6 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

